

хүрээлэнгийн дотоод, гадаад харилцаа хамтын ажиллагааны Цар хүрээ өргөжин тэлж, АНДБН-ийн асуудлыг улс үндэстэй, шинжлэн судлах ажлыг улам эрчимтэй хийж байна.

Л.Бэгзжав

АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

ӨВӨР МОНГОЛД ЗОРЧСОН ТЭМДЭГЛЭЛ

Л.Бэгзжав

Энэ 1997 онд БНХАУ-ын хувьд 3 том тэмдэглэлт үйл явдал тохиолоо. Нэг нь Англид 99 жилийн хугацаагаар түрээслэсэн Сянган буюу дэлхий нийтэд Хонконг гэж нэрлэсэн газар нутгаа эх орондоо эргүүлэн авсан, нөгөө нь тус улсын хамгийн ууган өөртөө засах орон болох Өвөр монголын өөртөө засах орон (ӨМӨЗО) байгуулагдсаны 50 жилийн ой, гуравдах нь XXI зууны босгон дээр Хятадын нэгэн зууны түүхийг нэгтгэн дүгнэж, шинэ зууны зорилтоо тодорхойлсон ХКН-ын XV их хурал хуралдсан зэрэг болно. Эхний хоёр том үйл явдал өнгөрөгч 7-р сард давхцсанаараа онцлог байлаа.

7-р сарын 1-нд Сянганы (Хятадаар "анхилуун боомт" гэсэн утгатай үг) Хятадад эргүүлэн авсны их баяр ёслолыг дуулиантай тэмдэглэсэн нь Азийн хүчирхэг "4 барын нэг"-ийг нэгтгэн авч БНХАУ-ын эдийн засаг, улс төрийн хүчин чадал эрс нэмэгдсэнийг дэлхий дахинаа харуулсан хэрэг байлаа.

7-р сарын 20-нд ӨМӨЗО байгуулагдсаны 50 жилийн ойг өргөн тэмдэглэсэн нь Хятадад үндэстний төрийн бодлого амжилттай хэрэгжиж цөм хамтаар хөгжин цэцэглэж байгаагийн бэлэгдэл болсон томоохон арга хэмжээ байв.

Нэг. Өвөр Монголын 50 жил

1947 оны 5-р сарын 1-нд ӨМӨЗО байгуулагдсан бөгөөд энэ өдрийг тус ӨЗО-ны баярын өдөр болгон тэмдэглэж байв. Хожим өөрчлөгдөж, ӨЗО-ны 40 жилийн ойг гэхэд л ХАУА-ийн баярын өдөр буюу 8-р сарын 1-нд тэмдэглэсэн билээ. Энэ удаад 7-р сарын 20-нд 50 жилийнхээ ойг тэмдэглэлээ.

Сүүлийн жилүүдэд, социалист гэгдэж байсан орнуудад түүхээ шинээр эргэж харах, үзэл суртлын нөлөөллөөс ангижруулах, бодитой дүгнэх, түүхэн үнэнийг сэргээх оролдого гарч байгаа нь хийгдэх ёстой залруулга мөн боловч түүхэн үнэний алдаа, оноо тухайн цаг хугацааныхаа хэмжээсэнд тэр л үнэнээрээ байх учиртай. Хятад улсын тухайд, Өвөр Монголын ойг өөр өөр өдөр тэмдэглэж байгаа нь улс орны дотоод амьдрал, цаг үеийн нөхцөл байдал, нийгэм сэтгэл зүйн олон учир холбогдолтой биз.

Ардчилсан шинэчлэлт өрнөж буй монгол оронд ч энэ үйл явц болж байна. Тухайлбал, Монголын ардын армийн 74 жилийн ойг жилийн өмнө тэмдэглэсэнээ, энэ жил Монголын армийн 86 жилийн ой болгон тэмдэглэх ч юм уу, Монголын ардын хувьсгалын уламжлалт тогтсон баяр наадмыг Монголын үндэсний баяр болгон агуулгыг "шинэчилж" түүхэн өөр үйл явдлуудыг "нэгтгэн" өнөөгийн цаг үеийн нөхцөл байдлаас субъектив үнэлэх, тухайн цаг төрийн бодлогод нийцүүлэх нь түүхийн үнэнд хэр ойртох бол?!

Энэ бүхнийг үл нуршин Өвөр Монголын өөртөө Засах орны 50 жилийн ойг тохиолдуулан тус ӨЗО-ны Зүүн Хойт Ази судлалын хүрээлэнгийн захирал, профессор Цао Жункайн санаачилгаар зохион байгуулсан хятад судлалын эрдэм шинжилгээний хуралд оролцох завшаанаар очсон газрынхаа сонинг уншигчидтайгаа товч хуваалцъя.

50 жилийн ойгоо тэмдэглэж буй ӨМӨЗО-ны засаг захиргааны төв Хөх

хотын гудамж талбайг өнгө өнгийн туг хиур, улаан дэнлүү, асан гялалзах гэрлэн чимэглэл, алаг цэцэгсээр нүд булааж, сэтгэл сэргэмээр сайхан чимэглэжээ. 40 гаруй үндэстнээс бүрдэх Өвөр монголын хүн ам 23 сая хүрч манай улсынхаас 10 дахин олон ч газар нутгийн хэмжээгээрээ хятадын бүх муж, хот, өөртөө засах орны дотор 3-рт ордог нь манайхаас 380 мянган км²-аар бага юм. Өвөр Монгол 50 жилийн дотор ялангуяа сүүлийн жилүүдэд үсрэнгүй хөгжиж улс ардын аж ахуйн бүх салбартаа ихээхэн амжилт оллоо. ӨМӨЗО жилд 73 сая т нүүрс олзворлож, 32 тэрбум киловатт эрчим хүч үйлдвэрлэж байгаа үзүүлэлтээрээ хятадын хэмжээнд 8, 15-р байранд явж байна. Зөвхөн 1996 онд 15.3 т үр тариа хураан авч, 1997 оны байдлаар 70 сая тоо толгой малтай болсон зэрэг хэдхэн жишээг дурдахад л хангалттай.

Анх 1554 оны хөх бар жил Түмэдийн Алтан хан Далан Хар уулын энгэрт хөх тоосгон байшин сууц бариулж эхэлснээр Хөх хот гэж нэрлэгдэн, хожмоо Гуйхуачэнь, Суйюань хот гэгдэж байснаа яг 400 жилийн дараа дахин Хөх хот нэрээрээ алдарших болов.

ӨМӨЗО байгуулагдсанаас хойш Хөх хот үндсээрээ өөрчлөгдөн шинэчлэгдэж, үндэстний өнгө төрхтэй орчин үеийн том хот болон өргөжин тэлж байна. Хөх хотын эдийн засгийн нээлттэй бүсэд сүндэрлэх улс хоорондын телефон утасны станцын 99.7 м өндөр, 21 давхар барилга хотын төв хэсэгт шинээр барьсан 3 давхар сүлжмэл гүүр, шинээр засаж тохижуулсан Цагаан суваргын нисэх онгоцны болон 5000 хүний хүлээлгийн тэнхим бүхий галт тэрэгний буудал, үзэсгэлэнгийн танхим, морин уралдааны талбай зэрэг том том сүрлэг барилга байгууламжийг ӨЗО-ны 50 жилийн ойг угтан бүтээн босгосныг Зүүн хойт ази судлалын хүрээлэнгийн орлогч захирал Насан, эрдэм шинжилгээний ажилтан Ван Вэньчяо нар тайлбарлан ярьж, дагуулан явж үзүүлсэнд талархах сэтгэлээ илэрхийлэхэд үг цөөднө. Дөнгөж ашиглалтанд орсон, 20 мянган м² талбайтай, 3 гол хэсэгтэй 3 сая ном багтаах агуулгатай 2000 хүн зэрэг ном унших 29 уншлагын тэнхим, ном олгох 7 газартай орчин үеийн уран барилгын загвар хийцийг монгол үндэстний өвөрмөц хэв төрхтэй хослуулан барьсан Хөх хотын номын сангийн 5 давхар сүрлэг барилгыг бахдан үзэж явахуйд Хятадын 1000 гаруй номын сангын дотор нэлээд дээгүүрт орох номын сандаа гэж тэндэхийн нэгэн ажилтан бүсгүй өгүүлсэн юм. Зах зээлд хөл хөл тавихдаа аймаг, сум албан байгууллага сургууль бүрд байсан номын сангуудаа бүгдийг шахам үгүй болгож, оргүй хоосон болсон бидэнд номын орд сүндэрлүүлж, ард түмнийхээ оюуны мэлмийг гүнзгийрүүлэхийн төлөө төр засаг нь онцгой анхаарч буй хятадын бодлогыг зах зээлийн шилжилт гэж ярихдаа нийгэм, соёлын түвшин эрс ангид хэт барууны маягийг даган бишрэгч зарим нэг "хэтэрхий мэргэн" дээдэс маань юу гэж үнэлэх бол хэмээн санагдаж байв.

Хоёр. Чингисийн онгонд

Хөх хотоос өглөө эртлэн баруун зүгийг барин Их зуу аймгийн Эзэн хороо суман дахь Чингис хааны онгоныг чиглэн, энхэл донхолгүй засмал замаар бүтэн 7-8 цаг явж зорьсон газраа ирлээ.

Чингисийн онгон орох замд Их зуугийн төв, 5-10 тэрбум тонн нүүрсний нөөцтэй 15 том уурхайн нэг орших Дуншэн хотоор дайрах юм. Энэ хотыг монголоор Шар хот гэх ажээ.

Чингисийн онгон бол Өвөр Монголын Ордосын өндөрлөгийн өмнө бие дээр Баян цанхагийн голын дэнж дэх Гандирын шилд оршдог. Онгон гэдэг бол хувилгаан сахиулсан, ариун голомт, халдаж үл болох дархан, эрхэм дээдээ хүндэтгэн сахих газар гэсэн утгатай билээ. Энэ нутагт яагаад Чингисийн онгоныг байгуулах болсон тухай нэгэн домог өгүүлье.

800-гаад жилийн тэртээ Чингис хаан Тангуудыг дайлаар мордох замдаа ургамал ногоо жигдэрсэн ус булаг ундарсан үзэсгэлэнт сайхан байгалийг ажин явахдаа ташуураа санамсаргүй унагачихаад түүнээ ч авхуулсангүй:

Өл буга идээшлэлтэй

Өвөөлжин шувуу өндөглэлтэй

Эвдэрсэн төрийг байгуулалтай

Энэ биеэ жаргуулалтай их сайхан газар байна хэмээн өгүүлжээ.

Мөн Чингис хаан тангуудыг дайлж яваад тэнгэрт хальсаны дараа энэ газраар дайран шарилыг нь тээж явсан хасаг тэрэгний бул шаварт зоогдож түмэн адуу мянган шараар татуулаад ч гаргаж дийлсэнгүйд их хааны сүнс хоргодож амрах нь гээд зарим хувцас хунар, эд зүйлсийг энд орхижээ.

Энэ нутагт Чингис хаан, Бөртө Үжин хатны цагаан ордныг анх тахиснаас "эзэн хороо" гэж нэрлэгдэх болж, хасаг тэрэг шаварт суусан газраас булаг оргилж, "Тогоо булаг" гэх болсон зэрэг домгийг нутгийн ардууд үе дамжин хэлэлцсээр иржээ.

Түүхэн сурвалж "Алтан товч"-д дээрхи домог бий. Үүнийг ор мөргүй домог гэхэд бэрхтэй ч түүхэн лавтай эх сурвалж бас үлдсэнгүй.

Д.Оссоны "Монголын түүх" номонд Чингис хааныг Онон, Хэрлэн, Туул голын эхэн болох Бурхан Халдун ууланд нутаглуулсан гэдэг. Монголын түүхийн "3 боть" зохиолд ч ийн бий. Чингисийн үед амьдарч байсан Сүн улсын элчин Сюй Тин 1237 онд "Би бээр Тэмүжиний бунханыг Онон голын хөвөөнд уулс усаар хүрээлэгдсэн газарт байхыг олж үзсэн" гэсэн тэмдэглэлд дэлхийн олон эрдэмтэд итгэдэг. Тэгвэл яриангүй Чингис хааны онгоныг Монгол газарт бий гэж олонхи эрдэмтэд үзсээр атал түүний онгоныг Ордосын өндөрлөгт тахидагийн учир түүхийн олон шалтгаантай билээ.

Чингисийн онгоныг хэдэнтээ нүүлгэсэн байна. 1939 оны 6-р сард Яньнаниар дайран Ганьсу мужийн Юйжун хошууны Синь Луншаньд нүүлгэх үед Мао Зэдун өөрийн гараар "Чэн-жи си хан жи нянь тан" гэсэн (Чингис хааны дурсгалын танхим) 7 үгийг ханз үсгээр томоор бичсэн гэдэг. 1949 онд Хөх нуур мужийн Хуан Жун хошууны Тар сүм буюу Гүмбүмд нүүлгэж, 1954 онд дахин Ордост авчирчээ. Хятадын засгийн газраас 880 мянган юань гаргаж Чингис хааны онгоны шинэ ордонг бариулж, ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын дарга Улаанхүү биеэрээ оролцон шавыг нь тавилцаж, 1956 оны 5-р сарын 15-нд нээсэн ажээ.

Соёлын хувьсгалын жилүүдэд ихээхэн эвдлэн сүйтгэсэн онгонг 1977 онд Хятадын засгийн газраас 350 мянган юань гарган засан сэлбэж, 1982 онд улсаас онц чухлаар хамгаалах соёлын өвд тооцож, Өвөр Монголын 40 жилийн ойгоор дахин 3 сая 700 мянган юань зарцуулан их засвар хийсэн байна. Чингисийн онгон 1991 онд Бүх Хятадын жуулчлалын шилдэг сайхан 40 газрын нэгд орж, 1996 оноос онгоныг бүх хятадын бага, дунд сургуулийн сурагчдыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх түшиц газрын нэг болгов.

Өөрөөр хэлбэл, Чингис хааны нэр Хятадад гадаад, дотоодын жуулчдыг татах, хүүхэд багачуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх хүчирхэг хэрэгсэл болон ашиглагдаж байна.

Энэ жил ӨМӨЗО-ы 50 жилийн ойг тохиолдуулан улсаас дахин 3 сая 300 мянган юань зарцуулж, Чингис хааны морьтой зэс хөшөө, дайны туг, хараа ихт хар сүлдний тахилгын тавцан, нийт 35, түүний дотор 16 гол байгууламжийг засаж, сэлбэж шинээр байгуулсан байна. Онгоны хүрэн дотор 2300 мөнх ногоон нарс, майлс, мод суулгаж гэр тэрэг, шар тэрэг мухлаг тэргийг шинээр тавьжээ.

Хүсэл мөрөөдлийн хүлэг гэж өнөө ч Ордосын монголчууд үүдэндээ хийсгэдэг аргамаг хүлэг, арслан, бар, хангарьд, луу 5 хүчтэнийг дүрсэлсэн, хөх, цагаан, улаан шар, ногоон 5 өнгийн хийморийн дарцаг Онгоны өргөн

талбайн өмнө салхинаа намирна.

Ерөөс монголчууд өнгөний билэгдэлийг бэлэгшээдэг. Хийморийн дарцагны хөх өнгө нь мөнх тэнгэрийг, цагаан нь эхийн сүүг, улаан нь хувь заяаг, шар нь газар шороог, ногоо нь ургамал моддыг бэлэгддэг.

Үүгээрээ нүүдэлч малчид газар тэнгэр, байгаль дэлхий, хүн ардын хүйн холибоог илэрхийлдэг. Зүүн хойт Хятадын Ляонин мужийн Монголжин хошуунд Их Монголын сүүлчийн хаан Лигдэн хутагтын байгуулсан Цагаан хотын туурь байгааг Монголын олон эрдэмтэд ирж судлаасай гэж уг хошууны багш нар хэвлэлд бичиж байсан. Өвөрмонголд Хөх хот, Шар хотоос гадна Хинган аймгийн төв Улаан хот ч гэж бий. Манайд ч Улаанбаатар, Улаангом, Цагаанхайрхан, Ногооннуур, Хөхморьт гэх мэт хот суурины нэрс элбэг. Буриадад ч Улаан-Үүд гэх мэт нэрс бас л бий.

Чингис хааны морьтой зэс хөшөөг үнэхээрийн сүрлэг сайхан болсныг бахдан харахдаа саяхан манай 1 хорооллын гүүрэн гарц дээрх солонгос хүний урласан гэх хөшөөг автобусанд явсан хоёр өвгөн хоньчин хүн гэмээр юм уу гэж өгүүлэхийг сонссоноо санангуут чухамдаа хөшөө дурсгал гэдэг чинь сүрлэг сайхан байж, тэр тусмаа морьтой баатарын хөшөөг монголын урчуул хийж чадахгүй гэж баймгүйсэн, харь хүний сэтгэлээр ур хийц төдийл сайнгүй, ийм хөшөөтэй болсондоо баярлах сэтгэл төрсөнгүйгээр үл барам, ядахдаа байрлалаа ер оносонгүйдээ гэж бодогдож байв.

Онгонд хүрэх шатны гишгүүр эртний уламжлалт заншлын дагуу 99 гишгүүртэй аж. Энэ бол санасан бүхэн сэтгэчлэн бүтэхийн зам мөр, монголчууд 99 тэнгэрт мөргөж, Чингис хаан 99 цагаан гүүний сүүгээр цацал өргөж, есөн ес наян нэгэн азарганы дэлээр хийсэн дэлхийд байхгүй содон хараа ихт хар сүлд гэх мэт монголчуудын тоон билэгдэлийн нэг болжээ. Нэг метр гаруй өндөр суурин дээр наран ургах зүг үүдийг харуулан барьсан их бага 3 монгол гэрийг хооронд нь хоёр гудам гарган 100 м урт зайнд холбон барьсан Чингис хааны онгоны орд Монгол үндэстний онцлогийг илтгэж чаджээ. Голын их гэр нь 24.81 м өндөр, зүүн баруун хоёр гэр нь тус бүр 18 м өндөр агаад, шар өнгийн шаазан вааран дээврийг нь хөх хөлтрөг гарган урласан, Чингисийн ордыг агаар дээрээс харах юм бол аварга хоёр жигүүрээ дэлгэн халин нисч буй бүргэд мэт харагдах нь Чингис хааны эр зориг, юунаас ч халирч буцахгүй Алтайн бүргэд мэт эрх чөлөөтэй, бишрэм хүндэтгэлтэйг илтгэсэн утгатай ажээ.

Гол ордонд цав цагаан хаш чулуугаар урласан Чингис хааны 4.3 өндөр суумал хөшөө, хөшөөний ар хананд, Чингисийн Ази Европыг хамарсан эзэнт их гүрний буюу "4 их хаант улсын" нутаг дэвсгэрийг ханын дэлгэмэл том зургаар дүрсэлж, хоёр талд нь Чингисийн эрдэнийн сэлэм, монгол жанжнуудын дуулга сэлтийг байрлуулжээ. Ордонд шарилын 3 гэр байрлуулжээ. Дунд талын том гэрт буй 3 авсны дундах нь Чингис хаан, Бөртө хатных, хоёр хажуугийнх нь Чингисийн дүү Хасар, Билгүүдэй нарынх, баруун гэрт нь Хулан хатных, зүүнд нь Гүрвэлжин хатны авсыг байрлуулжээ. Чингис хааны тахилгыг жил бүр 4 их, 30 гаруй бага тахилга, хийж тахидаг. 4 улирлын 4 их тайллага нь билгийн улирлын 3-р сарын 21-ны хаврын цагаан сүргийн их тайлга, 5-р сарын 15-ны зуны, 9-р сарын 12-ны намрын 10-р сарын 3-ны өвлийн их тайлга буюу 4 цагийн хурим үйлдэх ёслол болдог байна.

Чингис хааны онгон шүтээнийг сахин хамгаалж, тайж тахиулах албанд 40 түмэн хөх монголчуудаас сонгон авсан 500 өрхийн хүмүүсийг дархад буюу шар дархадууд гэдэг. XV зуунд ихэсийн орд, туг сүлдийг хамгаалдаг эдгээр улсыг ордос гэх болсон нь олон ордтой гэснээс үүссэн болой.

Дархадууд бол энгийн хүн, эгэл ардаас онцгой эрхтэй, цэргийн алба хашихгүй, албан татвар төлөхгүй, отго жинс хэрэглэдэггүй, тамга тэмдэг барьдаггүй онцлогтой, овгийн байгууллын шинжтэй, онцгой нийгмийн хүмүүс

юм. Чингисийн онгон шүтээнийг 700 гаруй жил ийн осолдолгүй сахин, шүтэн биширч ирсэн нь дэлхийд ховор, түүхэн уламжлал гэлтэй. Ордонд алт мөнгөн бидэртэй 2 том эмээл байна. Нэг нь эзэн Чингисийнх, нөгөө нь Их монгол улсын сүүлчийн хаан Лигдэн хутагт бөөрөгөнд нь нэрээ сийлсэн эмээл гэнэ. Дэлхийд хосгүй томоороо ижилгүй уран гоё хийцээрээ гайхагдсан Ази, Европ 2 тивийг холбон барилдуулсан утга их нягтралын хүчинг илтгэж хос 8 жирэмээр зангилагдсан энэ хоёр эмээл Гиннесийн номд ч бичигдэх учиртай гэж тэндэхийн тайлбарлагч өгүүлж байв.

Гурав. Тал нутгийн болд төмрийн хот

Хөх хот-Чингисийн онгон- Бугат Хөх хотын чиглэлээр аялан явах зуурт засмал зам тавьж буй тариачин ардууд үзэгдэнэ. Хүчирхэг машин техник хэрэглэхгүй ч гол төлөв хүрз жоотуугаар хичээнгүйлэн, махран ажиллаж, бүтээн бий болгож байгаа тэдэний ажилсаг, хөдөлмөрч хөдөлмөртөө үнэнч зүтгэхийг хэн ч хараад гайхан биширнэ. Хятадад "хурдан баяжихыг хүсвэл сайн замтай бол" гэсэн үг өргөн дэлгэрчээ. ӨМӨЗО 50 жилийн өмнө 1900 км замтай байсан бол 1997 оны эхээр 45.7 мянган км болж даруй 23 дахин уртассан байна. Өдгөө бүх районы 1566 сум, суурины 89% нь, 14284 гацаа тосгоны 63% нь засмал замтай болжээ. Замтай болно гэдэг баяжина гэсэн үг үнэн болох нь явсан газар бүр нүднээ илхэн байв.

ӨМӨЗО-ны 50 жилийн ойн өмнөхөн, Хөх хот-Бугатын өндөр хурдтай засвал зам ашиглалтад орлоо. 150.4 км үргэлжлэх энэ замын ар талаар үзүүр хязгаар нь үл харагдах Далан хар уул үргэлжилж, өмнө талаар нь цэлгэр уудам Түмэдийн тал, жимс ногооны талбай цэлийн байна. Хятадын ард түмэн бүтэн 4 жилийн шаргуу хөдөлмөрөөрөө 11 тэрбум 130 сая шоо куб метр газар шорооны ажил хийж, 3615 м том, дунд зэргийн 31 гүүр, хэд хэдэн урсгалтай сүлжмэл гүүр бүхий үнэхээрийн "алтан шар зам" байгуулжээ.

Нэг тэрбум 120 сая юаны хөрөнгө оруулалтаар энэ замыг барьсан ч хамгийн гол нь нөр шаргуу хөдөлмөр, хөдөлмөр зохион байгуулалтын хүчинд бий болжээ.

Бугат буюу хятадаар Баотоу хот бол ӨМӨЗО-ны хамгийн том аж үйлдвэрийн хот, хятадын харьцангуй том 13 хотын нэг юм. Өвөрмонголын баруун хэсгийн энэ хот хойгуураа Монгол улстай хиллэдэг бөгөөд Баянхонгор аймгийн нутгаас 4 дахин бага нутаг дэвсгэрт 37 үндэстний 2 сая хүн оршин суудаг.

50 жилийн тэртээ Бугат хот 70 мянган хүн амтай жижигхэн гацаа байсан бол өнөө ган.болд, автомеханик, хөнгөн цагаан, дулааны цахилгаан станц, нэхмэл, чихрийн зэрэг орчин үеийн томоохон үйлдвэрүүд сүндэрлэн боссон "тал нутгийн болд төмрийн хот" гэгдэх болжээ.

1996 онд Бугат хот Бүх хятадын ӨЗО-уудын дотор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ нь 20 тэрбум юанаас давсан 2 дахь хотоор шалгарчээ. Бугатын механикийн 1,2 -р үйлдвэр зэрэг нь тус улсын батлан хамгаалахын гол үйлдвэр, Хятадын анхны орчин үеийн байлдааны зэвсэг техник үйлдвэрлэсэн, олон төрлийн байлдааны зэвсэг төхөөрөмж болон 14 төрлийн автомашин үйлдвэрлэдэг хүчирхэг үйлдвэрүүд юм. 1997 оны эхээр Бугатад 10176 аж үйлдвэрийн газарт 600 мянган ажилчин албан хаагч ажиллаж 3000 гаруй төрлийн аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгааг статистикийн тоо баримт нотолж байна. 1959 онд Ерөнхий сайд Жоу Эньлай Бугатын ган төмрийн үйлдвэрийг нээх ёслолын улаан туузыг мөнгөн хайчаар хайчилан нээж байсан билээ. Өнөөдөр тус үйлдвэр хятадын 10 том болд төмрийн бааз газрын 5-рт ордог, жилдээ 4 сая тонн болд үйлдвэрлэж, 9 тэрбум юаны орлоготой ажилладаг үйлдвэр болжээ.

Бугат хот 1947 онд дөнгөж зургаахан жижиг үйлдвэртэй, нийтийн автобус ч үгүй, кино театр, цэцэрлэгт хүрээлэн ч үгүй, бүх хотдоо 63-хан модтой, 2591 км² нутагтай жижигхэн суурин байсанаа өнөө газар нутаг нь 602 дахин, хүн ам нь 15 дахин өссөн Өвөр монголдоо хамгийн анхны хий дамжуулах хоолой, дулааны төвлөрсөн хангамжтай хот болсон байна.

Бугат хот дэлхийн 40 гаруй улс, бүс нутагтай эдийн засаг, худалдааны харилцаатай, 1996 онд гадаад худалдааны экспорт, импортын хэмжээ 358 сая америк долларт хүрчээ. 1997 онд Бугатын 30 мянга гаруй дэлгүүр, худалдааны төвүүд, 5,6 тэрбум юаны жижиглэн худалдаа хийсэн нь 1950 оныхоос 400 дахин өсчээ. Бугатын их дэлгүүрүүд, Бүх хятадын хамгийн том худалдааны газруудын дотор 61-р байранд яваа аж.

27 салаа авто замаар хятадын бүх нутагт нэвтэрч чадах, өргөн уудам талбайтай өвч ногоон мод зүлэгтэй, цэвэр сайхнаараа үлгэр жишээ "ногоон хот" болсоноороо 3 жил дараалан шалгарсан Бугат хотын хөгжил дэвшил, Бүх хятадын, тэр дундаа Өвөр монголын хөгжил дэвшлийн нэгээхэн хэсэг билээ.

Л.Бэгзжав